



НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захирагааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2014.03.24 № 457.
таний _____-ны № _____-т

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Э.БАТТУЛГА ТАНАА

Р. Ариунзаян
Р. Түмбэ №/02.

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн аялал жуулчлалын газрын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад Нийслэлийн Аудитын газрын санхүүгийн аудитын IY баг аудит хийлээ.

Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл

Нийслэлийн аялал жуулчлалын газар санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй.

Санхүүгийн тайлан УСНББОУС, Сангийн сайдаас баталсан нягтлан бodoх бүртгэл, тайллагналын заавар, журмын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Аудитыг Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын холбоноос баталсан Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Үндэсний Аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн нэгдсэн тайлан дах дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлсийг сорилын үндсэн дээр шалгадаг. Нийслэлийн аялал жуулчлалын газрын удирдлагын ашигласан нягтлан бodoх бүртгэлийн зарчим, баримталсан бодлого, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланда дүгнэлт өгөх үндэслэл болсон.

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь УСНББОУС-ын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал: Төсвийн байгууллагууд санхүүгийн тайлангаа аккруэл сууриар бус, аккруэл-мөнгө хольсон сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандарттаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрхи заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн тайланг түүнтэй нийцүүлэн аudit хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн аялал жуулчлалын газрын 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангийн санхүүгийн нэгдсэн байдлын, санхүүгийн нэгдсэн үр дүнгийн, цэвэр хөрөнгө өмчийн нэгдсэн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангуудыг Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг зөрчилгүй толилуулсан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. ОЧИРБАТ